

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 25/05

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, “Бодь Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.12 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнг үндэслэн татварын дараах цэвэр ашгаас 1,141,377,290 (нэг тэрбум нэг зуун дөчин нэгэн сая гурван зуун далан долоон мянга хоёр зуун ер) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 5 (тав) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг 2025 оны 04-р сарын 30-ны дотор ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлсүгэй.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхжаргалд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БИЛЭГТ

## **“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 02-р сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал 2025 оны 02-р сарын 14-ний өдрийн 11:00 цагаас танхимаар ТУЗ-ийн дарга Б.Билэгт, Л.Болдхуяг, Ш.Бэжид, Б.Бүжинлхам, Л.Банзрагч, Г.Саруул гишүүд, цахимаар Ш.Сүхбаатар, Д.Даянбилгүүн, Э.Бямбажав гишүүд, Гүйцэтгэх захирал А.Энхжаргал болон удирдлагын багийн бүрэлдэхүүнтэйгээр танхим болон цахимаар хуралдаж 13:10 цагт дуусав.

### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны үр дүн танилцуулга түүнтэй холбоотой ногдол ашиг хуваарилах эсэх дээр шийдвэр гаргах,

А.Энхжаргал: 2024 оны цэвэр ашгаас Хувьцаа эзэмшигчидэд 1,141,377,290 төгрөгийг мөнгөн хэлбэрээр ногдол ашиг олгох боломжтой байна. Ногдол ашгийг 4 сарын 30-ны дотор ҮЦТХТ ХХК-р дамжуулан зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлнэ.

Б.Билэгт: Ногдол ашгийн нэгж хугацаанд ногдох хэмжээ хэд гэсэн үг вэ?

А.Энхжаргал: Нэгж хугацаанд ногдох хэмжээ 5 төгрөгөөр тооцож олгоно.

Л.Болхуяг: Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахыг дэмжиж байна.

Гишүүд 100 хувь дэмжив.

### **Шийдвэрлэсэн нь:**

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнг үндэслэн татварын дараах цэвэр ашгаас 1,141,377,290 (нэг тэрбум нэг зуун дөчин нэгэн сая гурван зуун далан долоон мянга хоёр зуун ер) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилах,
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 5 (тав) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг 2025 оны 04-р сарын 30-ны дотор ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлэх,
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоох,

Хурлын тэмдэглэлтэй танилцсан :

ТУЗ-ийн дарга

Б.Билэгт

ТУЗ-ийн гишүүд:

Л.Болдхуяг

Г.Саруул

Ш.Сүхбаатар

Д.Даянбилгүүн

Ш.Бэжид

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Э.Бямбажав

Л.Банзрагч

Б.Бүжинлхам

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ө.Батчимэг